



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5 дахь заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Авто зам, замын байгууламж бүлэгт хамаарах “Хотын авто зам төсөллөх ерөнхий шаардлага”, “Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад тавигдах ерөнхий шаардлага” 2 хотын стандартын төсөл боловсруулах 23/07 дугаарт гэрээний дагуу хийгдсэн зөвлөх үйлчилгээг хүлээн авах, дүгнэх Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Хотын стандартын төсөл боловсруулах ажлын даалгавар, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу хийгдсэн зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч дүгнэхийг Ажлын хэсэг (Э.Даваахатан)-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ